

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2018.12.03-12.07

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай хаагдлаа. АНУ-ын Засгийн газрын бондын өгөөж буурч, санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны ханш унасан бол дулаан, цахилгаан, ус хангамжийн компаниудын хувьцааны ханш өсчээ.

АНУ, БНХАУ-ын худалдааны маргаан хөрөнгийн зах зээлд нөлөөлсөн хэвээр байна.

Даваа гарагт АНУ, БНХАУ зөвшилцөлд хүрсэн талаар мэдээлэл гарч хөрөнгийн зах зээлийн индексүүд өсч эхэлсэн. Зөвшилцлийн дагуу БНХАУ АНУ-аас импортолдог хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүний хэмжээг нэмж, харин АНУ 90 хоногийн турш нэмэлт тарифын арга хэмжээг авахгүй байхаар тохиролцсон юм.

Мягмар гарагаас эхлэн АНУ-ын Ерөнхийлөгч БНХАУ-тай зөвшилцөлд хүрч чадах эсэхдээ эргэлзэж байгаа талаар мэдээлж хөрөнгийн зах зээлийн индексүүд унаж эхэлсэн.

Пүрэв гарагт АНУ БНХАУ-ын "Huawei" компанийн Санхүү хариуцсан захирлыг баривчлах талаар Канадад хүсэлт тавьж АНУ, БНХАУ-ын харилцаанд сөргөөр нөлөөлөв.

АНУ-ын цалингийн өсөлт таамагласан түвшинд хүрч чадаагүй байна. Ингэснээр тус улсын хөдөлмөрийн зах зээлийн өсөлтөд мөчлөгийн шинжтэй удаашрал үүсч байгаа аж.

Европ: АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргааны асуудал даамжирч Европын бүсийн хөрөнгийн зах зээлийн индексүүд буурлаа.

АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргааны асуудал Германы авто машин үйлдвэрлэгч болон аж үйлдвэрийн компаниудын ханш буурахад нөлөөлжээ.

"Brexit" хэлэлцээрийн төслийг тойрсон маргаантай холбоотойгоор Их Британийн FTSE 100 индекс 3 орчим хувиар буурав. Их Британийн Парламент тус төслийг дэмжихгүй бол тус улсын Ерөнхий сайд хатагтай Тереза Мэй болон түүний Засгийн газар огцрох аюултай байгаа юм.

Япон: Японы Nikkei 225 индекс 3 орчим хувиар унав.

3-р улиралд Япон улсын ДНБ Засгийн газрын таамаг хэмжээнээс илүү багассан байж болзошгүй хэмээн шинжээчид үзэж байна. Өмнө нь тус байгууллага энэ оны 7-9-р сард Японы эдийн засаг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1.2%-аар багассан талаар мэдээлж байсан бол уг тоог 1.9% болж өссөн гэж мэдээллээ.

11-р сард Япон улсын борлуулалтын менежерүүдийн индекс 2017 оны 8-р сараас хойшхи хамгийн доод цэгтээ хүрэв. Энэ нь Европ болон Хятадын талаас эрэлт буурсантай холбоотой аж. 11-р сард тус индекс өнгөрсөн сарын үзүүлэлтээс 0.7 оноогоор буурч 52.2 болжээ.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,486.30	-0.14% ▼
Dow Jones	АНУ	24,388.95	-4.50% ▼
S&P 500	АНУ	2,633.08	-4.60% ▼
Nasdaq	АНУ	6,969.25	-4.93% ▼
S&P/TSX	Канад	14,795.13	-2.65% ▼
FTSE 100	Их Британи	6,778.11	-2.90% ▼
S&P/ASX 200	Австрали	5,681.50	0.25% ▲
Nikkei 225	Япон	21,678.68	-3.01% ▼
Hang Seng	Хонг Конг	26,063.76	-1.67% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	107.56
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	95.43
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	94.19
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	110.43
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.73
DBM' 2023	USD	7.250%	98.65
TDBM' 2020	USD	9.375%	104.17

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.400	0.05 ▲
Libor 3M	2.770	0.03 ▲
Libor 6M	2.890	0.00 ▼
Libor 1YR	3.100	-0.02 ▼
US 2YR Bond	2.831	0.00 ▼
US 3YR Bond	2.695	-0.16 ▼
US 5YR Bond	2.696	-0.18 ▼
US 10YR Bond	2.674	-0.36 ▼

Валютын ханш /төг/

Валют	2018.12.07	Өөрчлөлт
USD	2,634.50	0.28% ▲
CNY	382.72	1.16% ▲
EUR	2,995.82	0.25% ▲
RUB	39.41	-0.13% ▼
KRW	2.35	0.43% ▲
JPY	23.36	0.91% ▲
CAD	1,967.07	-0.42% ▼

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,248.09	1.95% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	14.57	1.96% ▲
Зэс	USD/lb.	273.90	-3.64% ▼
Нүүрс	USD/MT	102.00	0.39% ▲
WTI газрын тос	USD/bbl.	52.42	-2.38% ▼
Brent газрын тос	USD/bbl.	61.9	-0.69% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	4.56	1.56% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018. X	6.30%
Бодлогын хүү	2018. XI	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. X	10.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. X	12.30%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. X	5.40%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. X	17.40%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. X	10.70%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 41 компанийн 892.3 сая төгрөгийн 3,731,166 ширхэг хувьцаа арилжигдав.

“Хөвсгөл алтан дуулга” /ADU/ компанийн хувьцаа 23.91%-аар буюу хамгийн ихээр өсч 1,140 төгрөгт хүрч хаагдсан бол “Хай би ойл” /HBO/ компанийн хувьцаа 27.45%-аар буурч 38.45 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.


12-р сарын 07-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,310.3 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,486.30 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.14%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2018 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	892.3
Зах зээлийн үнэлгээ	2,310,319.5

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,486.30	-0.14% ▼
MSE I индекс	9,295.45	0.26% ▲
MSE II индекс	8,593.74	1.64% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Ард даатгал	327,146	245,823,036
АПУ	362,839	206,538,685
ЛэндМН ББСБ	2,670,291	182,933,784
Жинст-Увс	45,663	80,720,139
Мандал даатгал	13,982	67,338,010

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Хөвсгөл алтан дуулга	1,140.00	23.91% ▲
Материалимпекс	8,445.00	13.58% ▲
Женко тур бюро	85.00	13.33% ▲
Оллоо	60.00	9.09% ▲
Стандарт проперти групп	170.00	4.10% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Хай би ойл	38.45	-27.45% ▼
Фронттиер лэнд групп	170.00	-15.00% ▼
Хэрлэн хивс	78.00	-14.29% ▼
Хөвсгөл хүнс	1,175.00	-14.05% ▼
Орхондалай	2,100.00	-12.50% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Ард секюритиз	552,564,793
Мирэ Эссет Секьюритис Монгол	311,449,995
Би Ди Сек	284,383,914
Голомт капитал	261,000,206
Бумбат-Алтай	106,330,854

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	572.60	609,350
Таван толгой	6,650.00	350,224
Говь	33,000.00	257,437
МИК	10,350.00	214,341
Сүү	220.00	75,680

ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны анхдагч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.08.31	2018.09.10	2018.10.10-нд олгов
2	ERS	Монгол алт	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
3	TEE	Тээвэр дархан	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
4	TTL	Таван Толгой	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.06.12-нд олгов
5	EER	Ариг гал	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с
6	BDL	Могойн гол	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	2018.06.26-нд олгов
7	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с
8	TAL	Талын гал	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор
9	BRC	Барилга корпораци	700.00	28.46	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
10	AND	Анд-Энерги	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
11	SUL	Жуулчин дюты фрий	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с
12	GTL	Гутал	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с
13	BNG	Баянгол зочид буудал	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с
14	APU	АПУ	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.05.17-нд олгов
15	BTG	Баянтээг	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
16	MIE	Материалимпекс	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.04.17-нд олгов
17	HRD	Хүрд	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор
18	SUU	Сүү	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.06.04-нд олгов
19	MNP	Монгол шуудан	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.06.05-нд олгов
20	MMX	Махимпекс	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с
21	TCK	Талх чихэр	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с
22	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	2018.03.06	2018.09.21-нд олгов
23	ADL	Адуун чулуун	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	2018.06.26-нд олгов
24	TAH	Тахь-ко	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор
25	UBH	Улаанбаатар хивс	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с
26	GOV	Говь	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с олгов
27	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.04.12-нд олгов

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Говь” ХК-ийн үнэт цаасны арилжааг түр зогсоолоо

СЗХ-ны 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар “Говь” ХК-ийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөнтэй холбогдуулан Улсын байцаагчийн 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 57 тоот албан шаардлагын дагуу тус компанийн арилжааг 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн түр хугацаагаар зогсоолоо.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж




ҮЦТХТ: “Мах импэкс”, “Монгол шуудан”, “Сүү” ХК-ийн хувьцааны төвлөрөл буурсан

“Мах импэкс”, “Монгол шуудан” болон “Сүү” компанийн хувьцааны төвлөрөл 11 дүгээр сарын эцсийн байдлаар оны эхэн үетэй харьцуулахад буураад байна. Тухайлбал, энэ оны эхэнд “Сүү” компанийн нийт хувьцааны 93.8 хувийг гурван том хувьцаа эзэмшигч, үлдсэн 6.2 хувийг 1,100 орчим жижиг хувьцаа эзэмшигч эзэмшиж байжээ.

11 дүгээр сарын Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн судалгаанаас харахад нийт 1,600 гаруй жижиг хувьцаа эзэмшигч тус компанийн 7.3 хувийг эзэмшиж байна. Өөрөөр хэлбэл жижиг хувьцаа эзэмшигчдийн эзэмших хувь 17 гаруй хувиар өсчээ. “Сүү” компанийн нэгж хувьцааны ханш хамгийн сүүлийн байдлаар буюу Мягмар гарагийн хаалтын ханшаар 220 төгрөг болсон байна. Түүнчлэн “Монгол шуудан” компанийн жижиг хувьцаа эзэмшигчдийн эзэмших хувь нь 50 гаруй хувиар нэмэгдээд байгаа аж. Оны эхэнд тус компанийн 5.7 хүрэхгүй хувьд 700 гаруй хөрөнгө оруулагчид байсан бол 11 дүгээр сарын эцэст 8.8 хувьд нь 820 хөрөнгө оруулагч болж өсчээ. “Монгол шуудан” компанийн хувьцааны ханш сүүлийн нэг сарын хугацаанд 13 хувиар өсөж, 588 төгрөгт хүрээд байна.

Харин Монголын хөрөнгийн бирж болон Монголын үнэт цаасны биржид бүртгэлтэй компаниудаас “Женко тур бюро”, “Улсын их дэлгүүр” компаниуд хамгийн олон жижиг хувьцаа эзэмшигчидтэй байгаа аж. Эдгээр компаниудын дараа “Говь” компани 16 мянга гаруй хувьцаа эзэмшигчидтэйгээр бичигдэж байна. “Говь” компани хувьцаа эзэмшигчдийнхээ тоог нэмэгдүүлж, хөрвөх чадвараа өсгөх зорилгоор аравдугаар сард нэгж хувьцаагаа 100 хуваах шийдвэр гаргасан юм. Улмаар 11 дүгээр сарын 30-нд Санхүүгийн зохицуулах хороо дээрх шийдвэрийг зөвшөөрснөөр Монголын Хөрөнгийн бирж тус компанийн арилжааг түр хугацаанд зогсоогоод байна.

Эх сурвалж: BloombergTv.mn



2018 онд 10 орчим андеррайтерийн компани хөрөнгийн захад шинэ бүтээгдэхүүн хамтран гаргажээ

2018 онд хөрөнгийн зах зээлд шинээр гарах бүтээгдэхүүний тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор мэргэжлийн компаниудын хамтын ажиллагаа өргөжиж байгааг Санхүүгийн зохицуулах хороо онцлолоо.

Тухайлбал, компанийн засаглалыг сайжруулах үүднээс зөвлөх үйлчилгээний компаниуд хамтарч ажиллаж байгаа юм. Сүүлийн 1-2 жилд хөрөнгийн зах зээл идэвхжсэн нь зөвлөх компаниудын үйл ажиллагаанд эергээр нөлөөлж, ач холбогдлыг нь ойлгож байгааг “BDO Аудит” компанийн Гүйцэтгэх захирал мэдээллээ.

Мөн компаниуд IPO гаргахад хамгийн гол үүрэг гүйцэтгэдэг андеррайтер компаниудын тоо энэ онд 25 болж нэмэгдээд байна. Санхүүгийн зохицуулах хорооны сүүлийн хуралдаанаар Тээвэр хөгжлийн банкинд үнэт цаасны зах зээлд андеррайтерийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгоод байгаа юм. Эдгээр андеррайтерийн компаниуд дотооддоо том хэмжээнд тооцогдох IPO-нууд дээр хамтран ажиллаж, амжилттай болгоход анхаарч байгааг “Би Ди Сек ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал онцолж байна.

Үүнээс гадна дан ганц компанийн эрх ашиг бус хөрөнгө оруулагчдад найдвартай, бодит үнэлгээ бүхий компаниудыг санал болгохоор зорин ажиллаж байгаа юм. Энэ онд дөрвөн компани IPO гаргаж, Монголын хөрөнгийн биржид нэг компани давхар бүртгүүлж, бүртгэлтэй нэг компани нэмж хувьцаа гаргасан байна. Үүнд 10 орчим андеррайтер компани туслах болон үндсэн үүргийг гүйцэтгэн ажиллажээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

Хөрвөх чадвар сайтай 10 ХК-ийн хувьцааны ханшийн таамаглал

Дотоодын хөрөнгийн зах зээлд арилжаа нь идэвхтэй явагддаг, хөрвөх чадвар сайтай 10 компанийн ханшийн таамаглалыг Marketinfo.mn сайтаас танилцууллаа.

Ирэх оны I улирал дуусахад эдгээр “Топ 10” компанийн хувьцааны ханш ямар түвшинд байхыг тооцоолсон есөн шинжээчийн ханшийн таамаглалыг нэгтгэсэн байна. “Топ 10” компанид МХБ-ийн I ангилалд бүртгэлтэй, хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй “Сүү”, “Тавантолгой” зэрэг томоохон компаниудаас гадна “Айтүүлс”, “Лэндмн” зэрэг хөрөнгийн захын отгон тоглогчид ч багтаж байгаа юм.

“Сүү” компанийн хувьцаанд дийлэнх шинжээчид “Hold” буюу “Хүлээх хэрэгтэй” гэсэн зөвлөмжийг илүүтэйгээр санал болгожээ. Тухайлбал, “Бумбат-Алтай” үнэт цаасны компанийн шинжээч Ц.Наран-Учрал “Хагас жилийн санхүүгийн үзүүлэлт өмнөх жилүүдээс эрс сайжирсан ч хувьцааны үнэ ашгийн харьцаа нь ижил I ангиллын хувьцааны дунджаас өндөр хэвээр байна” гэж үзэж байгаа юм.

Харин АПУ компанийн хувьцааг есөн шинжээч 100 хувийн саналаар худалдан авах хэрэгтэй гэж үзжээ. Тус компанийн хувьцааг ирэх оны I улирлын эцэст 620-850 төгрөгт хүрнэ гэж шинжээчид таамаглаж байна. Өөрөөр хэлбэл, “АПУ” ХК-ийн хувьцааны ханш хамгийн сүүлийн байдлаар 569 төгрөг байгаа нь шинжээчдийн таамаг үнийн хамгийн доод түвшнээс бага байгаа аж.

Эх сурвалж: BloombergTv.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Оны эхний 11 сарын байдлаар Монголбанк 18.9 тонн алт худалдан аваад байна

11 дүгээр сард 1.2 тонн алт худалдаж авсан гэж Монголбанк мэдээллээ. Ингэснээр оны эхний 11 сарын байдлаар Монголбанкны худалдан авсан нийт алтны хэмжээ 18.9 тонн хүрлээ. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 200 орчим кг-аар бага дүн болж байна. Байршлаар нь авч үзвэл тайлант сард Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 93.3 кг алт, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 41.6 кг алтыг худалдаж авсан үзүүлэлттэй байна. Өмнөх онд 20 тонн алт худалдан авч түүхэн дээд хэмжээг тогтоосон Монголбанк энэ онд 22 тонн алт худалдаж авах зорилго тавьсан гэж мэдээллээ.

Алт тушаалтыг нэмэгдүүлснээр гадаад валютын албан нөөцийг зохистой хэмжээнд хүргэнэ гэж Монголбанк үзэж байна. Энэ хүрээнд Ашигт малтмалын нөөц ашигласны татвар 2.5 хувийг 2024 он хүртэл таван жилээр сунгах хуулийн төслийг нэр бүхий гишүүн санаачлан УИХ-д өргөн бариад байна. Алтны татварын хөнгөлөлтийг сунгаснаар алт тушаалт нэмэгдэх боломжтой гэсэн саналыг Монголбанк өмнө нь гаргаж байсан юм.

Алтны спот ханш сүүлийн байдлаар 1,222 ам.доллар орчимд хэлбэлзэж байна. Энэ оны наймдугаар сард 1,174 ам.доллар хүрч унаад байсан алтны ханш эргээд дөрөв орчим хувиар өсчээ.

Эх сурвалж: BloombergTv.mn



Шатахууны үнэ 100 төгрөгөөр буурчээ

"Шатахууны худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд жижиглэнгээр борлуулж буй шатахууны үнийг эдийн засгийн зохистой түвшинд тогтвортой байлгах" заалтыг хэрэгжүүлэх, мөн шатахууны хилийн үнэ буурсан үед жижиглэнгийн үнийг буулгах чиглэл хүргүүлсний дагуу 12-р сарын 7-ны өдрөөс эхлэн шатахууны үнэ 100 төгрөгөөр буурлаа хэмээн УУХҮЯ-аас мэдээллээ.

Цаашид шатахууны үнэ үе шаттайгаар буурахыг салбарын яам мэдэгдсэн юм. Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ ОХУ, ОПЕК-ийн орнуудын бодлого болон олон улсын геополитикийн зөрчлөөс шалтгаалан 2018 оны эхнээс эхлэн өсч байсан боловч энэ оны 10 дугаар сарын дунд үеэс газрын тосны үнэ огцом буурсан. 11 дүгээр сарын 27-ны өдрийн арилжаагаар "Брент" төрлийн газрын тосны үнэ нэг баррель нь 60.22 ам.долларт хүрсэн юм.

Мөн ОХУ-ын "Роснефть" компаниас нийлүүлж буй шатахууны энэ сарын хилийн үнэ өмнөх сартай харьцуулахад бүтээгдэхүүний төрлөөс хамааран тонн тутамдаа 82-148 ам.доллараар буурч, Аи-92 автобензин 617 ам.доллар/тн, дизелийн түлш 706 ам.доллар/тн болоод байна.

Эх сурвалж: Montsame.mn


"Xanadu Mines" Торонтод хувьцаагаа арилжаалж эхэлснээс хойш ханш нь 6 хувиар буурав

Австрали, Торонтогийн Хөрөнгийн биржид давхар бүртгэлтэй "Xanadu Mines" компанийн хувьцааны ханш Торонтогийн Хөрөнгийн биржид даваа гарагийн арилжаагаар 17.6 хувиар буурч, 0.14 канад доллар болсон байна.

Тус компани хувьцаа гаргах зөвшөөрлөө аравдугаар сард авч, 10-р сарын 31-нээс арилжаагаа эхэлсэн юм. Түүнээс хойш хувьцаа нь зургаа орчим хувиар буураад байна. Харин Австралийн Хөрөнгийн биржид хамгийн сүүлд нэгж хувьцааны ханш нь 0.13 австрали доллар боллоо.

"Xanadu Mines" компани "Хармагтай" төслийн нөөцийн төлөвөө шинэчлэн тогтоогоод байгаа юм. 2015 онд танилцуулсан нөөцийн дүнтэй харьцуулахад зэсийн агууламж 400 хувь, алтны агууламж 249 хувиар өссөн гэж үзжээ. 9-р сарын 30-ны байдлаар тус компанийн бэлэн мөнгөний тэнцэл 7.8 сая австрали доллар болсон талаар санхүүгийн тайландаа дурдсан байна.

Эх сурвалж: BloombergTv.mn




Шивээхүрэн-Сэхэ чиглэлийн төмөр замыг Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлтэй хамтад нь барина

Шивээхүрэн-Сэхэ чиглэлийн төмөр замыг нарийн царигтай барихаар шийдвэрлэснийг Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замтай хамтад нь барих нь зүйтэй гэж Засгийн газар үзлээ. Ингэснээр нүүрсний экспорт жилд 18-20 сая тонн хүртэл нэмэгдэнэ гэсэн тооцоо гарсан байна. Иймээс "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай" УИХ-ын 2014 оны 64 дүгээр тогтоолд "Нарийнсухайт-Шивээхүрэн" гэж нэмэх төсөл боловсруулан өргөн мэдүүлэхээр боллоо.

Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлд төмөр замтай болсноор нүүрсний экспорт болон боомтын нэвтрүүлэх хүчин чадал гурав дахин нэмэгдэж, тээврийн өртөг 2-4 дахин буурч, байгаль орчин, экологид учрах сөрөг нөлөөлөл багасах зэрэг олон давуу талтай юм.

Нарийнсухайтын бүлэг орд нь уул уурхайн салбарын экспортын 50 хувийг дангаараа гаргадаг том орд учир тэнд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийг дэмжих ёстой гэж Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумьяабазар хэллээ гэж Засгийн газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсээс мэдээллээ.

Эх сурвалж: MongolianMiningJournal.com



БУСАД МЭДЭЭ

Төвбанк төгрөгийн ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах арга хэмжээ авч байна

Олон улсын санхүүгийн зах зээл дэх ам.долларын өгөөж нэмэгдсэн, дотоодын эдийн засагт үүсээд буй түр зуурын шинжтэй хүчин зүйлсээс шалтгаалан сүүлийн үед төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах хандлага ажиглагдах болсон.

Төгрөгийн ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор Монголбанк энэ оны 2 дугаар хагаст нийт 1.0 тэрбум ам.долларыг нийлүүлсэн бөгөөд 11 дүгээр сар гарснаас хойш нийт 375 сая ам.долларыг захад нийлүүлээд байна. Улмаар өнгөрсөн 11 дүгээр сарын 07-ны өдрөөс хойш тасралтгүй сулраад байсан төгрөгийн ханш 12 дугаар сарын 05-ны өдөр 5.02 төгрөгөөр чангарсан байна.

Түүнчлэн хэрэглээний зээлийг хязгаарлах зорилгоор хэрэглээний зээлийн хугацааг 30 хүртэл сар болгох, хэрэглээний зээлийн өр орлогын харьцааг 70 хувиар тогтоох, валютын зээлийн эрсдэлийн жинг нэмэгдүүлснээр банкуудын гадаад валютаар зээл олгох сонирхлыг бууруулах, бодлогын хүүг 1 нэгж хувиар нэмэгдүүлэн, 11 хувьд хүргэснээр төгрөгийн харьцангуй өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээ аваад байгааг Төвбанкнаас мэдээллээ.

Эх сурвалж: Montsame.mn

10-р сарын байдлаар байгууллагын зээлийн 37.2 хувийг гадаад валютын зээл бүрдүүлжээ

10-р сард байгууллагын хадгаламжийн 41.3 хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байна. Энэ нь өмнөх сараас 4.1 нэгж хувиар өссөн үзүүлэлт гэж Монголбанк мэдээллээ.

Харин байгууллагын зээлийн 37.2 хувийг гадаад валютын зээл бүрдүүлж байна. Энэ нь 9-р сараас 1.5 нэгж хувиар буурсан үзүүлэлт болжээ. Тайлант сард валютын зээлийн жигнэсэн дундаж хүү 10 хувь байна. Харин төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 17.6 хувь буюу 7.6 нэгж хувиар өндөр байгаа юм. "Өрхийн өр хэт нэмэгдэх, банкнуудын баланс дээрх долларжилт нэмэгдэх нь эдийн засгийг илүү эмзэг болгох эрсдэлтэй" гэж Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан онцолж байна.

9-р сарын Мөнгөний бодлогын шийдвэрийн хүрээнд санхүүгийн долларжилтыг бууруулахын тулд гадаад валютын зээлийн эрсдэлийн жинг 150 хувь болгож өсгөх шийдвэр гаргасан нь 2019 оны нэгдүгээр сарын нэгнээс хэрэгжиж эхэлнэ. Мөнгөний бодлогын мэдэгдэлд "Гадаад валютын орлогогүй, валютын ханшийн эрсдэлийг удирдах бололцоо хязгаарлагдмал иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад гадаад валютын зээл олгох нь өрийн дарамт, эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлнэ" гэж Төв банк дурджээ.

Салбараар нь авч үзвэл худалдаа, уул уурхай, барилгын салбарт гадаад валютын зээл бусад салбараас өндөр байна. Үүнээс худалдааны салбарт олгосон гадаад валютын нийт зээлийн 31 хувийг эзэлж байгаа нь оны эхнээс дөрвөн нэгж хувиар нэмэгдсэн үзүүлэлт юм.

Эх сурвалж: BloombergTv.mn



ГШХО 1.4 тэрбум ам.доллар болж өссөн ч уул уурхайн салбарын цөөн компанид төвлөрч байна

10-р сарын байдлаар Монгол Улсад 1.4 тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 381 сая ам.доллаароор өссөн үзүүлэлт боллоо.

2016 онд -400 сая ам.доллар хүрч буураад байсан гадаадын шууд хөрөнгө оруулалт сүүлийн хоёр жилд нэг тэрбум ам.доллар даваад байгаа юм. Хэдий тийм боловч 2011, 2012 онд буюу гадаадын шууд хөрөнгө оруулалтын оргил үед 4.5 тэрбум ам.доллар хүрч байв.

Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалтын дүн өсөж байгаа ч төвлөрөл их байгаа аж. Тухайлбал, 1-2 томоохон компанийн нөлөө гадаадын шууд хөрөнгө оруулалтад их байна гэж Азийн хөгжлийн банк мэдээлж байсан юм. Тухайлбал, энэ онд "Оюу Толгой" ХХК-ийн гүний уурхайн бүтээн байгуулалттай холбоотой гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдсэн гэж Сангийн яам мэдээллээ. Мөн ирэх онд далд уурхайн бүтээн байгуулалтад 1.3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэх төлөвтэй байна гэж Сангийн яам 2019 оны төсвийг боловсруулахдаа онцолсон юм.

Дэлхийн банкны тайлангаас харвал 2017 оны жилийн эцсийн байдлаар БНХАУ, Канад улсаас Монгол Улсад оруулсан хөрөнгө оруулалт нийт хөрөнгө оруулалтын талаас илүү хувийг эзэлж байна. Харин салбараар нь авч үзвэл 70 гаруй хувь нь уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт байгаа юм.

10-р сард төлбөрийн тэнцлийн алдагдал өмнөх сараас 424 сая ам.доллаароор буурч, 51 сая ам.долларт хүрсэн гэж Төв банк мэдээллээ. Төлбөрийн тэнцлийн алдагдал буурахад Хөгжлийн банкны олон улсын зах зээлээс татан төвлөрүүлсэн 500 сая ам.долларын бондын санхүүжилт нөлөөлснийг Монголбанк мэдээлсэн юм. Хэдий тийм боловч тайлант хугацаанд урсгал дансны алдагдал 180.3 сая ам.доллаароор өсч, 1.3 тэрбум ам.долларт хүрсэн байна. Урсгал дансны алдагдал өсөхөд импортын өсөлт, гадаадаас авдаг тээвэр, аялал жуулчлал болон бусад өндөр төлбөртэй үйлчилгээний дансны алдагдал голлон нөлөөлжээ. Олон Улсын Валютын Сангийн зургаа дахь шатны үнэлгээний ажлын хэсгийн дүгнэлтэд урсгал дансны алдагдал өсөх төлөвтэй байгааг анхааруулаад байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.